

LEGAL NEWSLETTER

www.akp.mn
MAY 15, 2026 NO 62



Татварын шинэчлэлийн талаар

Бид энэ дугаарт Татварын хууль тогтоомжийн өөрчлөлтийг танилцуулж байна.

2026 оны 5 сарын 7-ны өдөр УИХ-д татварын дараах хууль тогтоомжийн шинэчилсэн төсөл өргөн баригдсан болно.

- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын хууль

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ, олон улсад өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлнэ зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.2-т “бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшинэ”, 4.1.5-д “бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тус тус тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны өрсөлдөх чадвар сайжирч, бизнес эрхлэгчдийн татварын ачаалал буурна.

01. НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Энэ хууль нь батлагдвал 2027 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

	Үзүүлэлт	Одоогийн хууль (2015)	Шинэчилсэн төсөл (2026 оноос)
1	НӨАТ-ын босго (НӨАТХ 4.1.8)	Үйл ажиллагааны борлуулалтын орлого 50 сая төгрөг	Үйл ажиллагааны борлуулалтын орлого 400 сая төгрөг
2	НӨАТ төлөх хугацаа (НӨАТХ 16.1)	Тухайн сарын НӨАТ-ыг дараа сарын 10-ны өдөр төлнө.	Хууль даган мөрдөлтийн түвшин “сайн” буюу түүнээс дээш үнэлгээтэй албан татвар суутган төлөгч хүсэлт гаргасан тохиолдолд албан татвар төлөх хугацааг 1 сар хүртэл хугацаагаар хойшлуулна. Үүнийг хугацаанд нь төлсөн татвар төлөгч дахин хүсэлт гаргасан тохиолдолд албан татвар төлөх хугацааг 2 сар хүртэл хугацаагаар, сар бүр тэнцүү хэмжээгээр төлөх нөхцөлтэйгөөр хойшлуулна.
3	Импортын барааны НӨАТ төлөх хугацаа (НӨАТХ 16.1)	Тухайн сарын НӨАТ-ыг дараа сарын 10-ны өдөр төлнө.	Мөн дээрхтэй адил хугацаагаар хойшлуулж төлж болно.

02. ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

Энэ хууль нь батлагдвал 2027 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

	Үзүүлэлт	Одоогийн хууль (2019)	Шинэчилсэн төсөл (2026 оноос)
1	Албан татвараас чөлөөлөх орлого (ХХОАТХ 22.1)	Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлогын татвар 2%	Монгол Улсын иргэний үргэлжилсэн 5-аас доошгүй жилийн хугацаанд өмчилсөн бөгөөд өөрийн үндсэн оршин суух хаягт бүртгэлтэй амьдран суух зориулалттай орон сууцаа борлуулж олсон орлогын албан татварын 2%-ийн татвараас чөлөөлөгдөнө.
2	Албан татвар ногдох орлого (ХХОАТХ 15.6)	50 сая орлогод 1%	Татварын жилийн баталгаажсан тайлангаар 1 тэрбум хүртэлх төгрөгийн албан татвар ногдох орлоготой бол тухайн орлогын дүнгээс 1%-ийн татвар төлнө.
3	Албан татварын хөнгөлөлт (ХХОАТХ 23.1)	Жилийн 36,000,000 төгрөг хүртэлх орлоготой бол 120,000-240,000 т төгрөгний хооронд хөнгөлдөг. 36,000,000 төгрөгөөс дээш орлоготой бол хөнгөлөлт байхгүй	Тухайн жилийн нийт 9,504,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдох албан татварыг 100 хувиар хөнгөлнө.

03. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

Энэ хууль батлагдвал 2027 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

	Үзүүлэлт	Одоогийн хууль (2019)	Шинэчилсэн төсөл (2026 оноос)
1	Элэгдэл (ААНОАТХ 17.1)	-	Их хэмжээний өгөгдлийг өндөр хурдтай хадгалах, автоматаар боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж, график процессор бүхий сервер, супер компьютерын хувьд, элэгдэл тооцох хугацаа 3 жил байна.
2	Албан татварын хөнгөлөлт үзүүлэх орлого (ААНОАТХ 22.5.23)	улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш 5 жилийн хугацаанд Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг;	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг
3	Албан татварын хувь хэмжээ (ААНОАТХ 25.1)	<ul style="list-style-type: none"> 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10%, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25% 	<ul style="list-style-type: none"> 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10%, 6-10 тэрбум хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 15%, 10 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 1 тэрбум 200 сая төгрөг дээр 10 тэрбумаас дээш давсан орлогод 25%.
4	Татварын 90%-ийн хөнгөлөлт (ААНОАТХ 20.1)	Жилийн 1.5 тэрбум хүртэлх орлоготой бол 10%-ийн татвар төлөөд 90%-ийг буцааж авдаг.	Жилийн 2.5 тэрбум хүртэлх орлоготой бол 10%-ийн татвар төлөөд 90%-ийг буцааж авна.
6	Татвар тайлагнах хугацаа (ААНОАТХ 25, 26)	<ul style="list-style-type: none"> Улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор Жилийн эхний хагас жилийн татварын тайланг 07 дугаар сарын 20-ны дотор Жилийн эцсийн тайланг дараа ооны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ. 	Бүх “10-ны дотор”, “20-ны дотор” гэснийг “сүүлийн өдөр” болгож өөрчилж, хойшлуулж өгсөн.
7	Тусгайлсан харилцаа (ААНОАТХ 29, 30, 31)	<ul style="list-style-type: none"> Улирал бүр төлөх татвараа дараа улирлын эхний сарын 20-ны дотор, Жилийн эцсийн тооцооны дагуу татвараа дараа оны 02 дугаар сард багтаан төлнө. 	Бүх “10-ны дотор”, “20-ны дотор” гэснийг “сүүлийн өдөр” болгож өөрчилж, хойшлуулж өгсөн.

04. ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Энэ хууль батлагдвал 2027 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

	Үзүүлэлт	Одоогийн хууль (2019)	Шинэчилсэн төсөл (2026 оноос)
1	Татварын нэхэмжлэх (ТЕХ 51)	Зохицуулалт байхгүй	Маргаан таслах зөвлөл, шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа нөхөн ногдуулалтын актад заасан алданги, торгуулийг тухайн гомдлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд татвар төлөгчөөс нэхэмжлэхгүй
2	Татварын өрийг үл маргах журмаар гаргуулах (ТЕХ 63)	Зохицуулалт байхгүй	Татварын өрийг гаргуулсны дараа татвар төлөгчийн банкин дахь дансанд ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар гаргуулах татварын өрийн хэмжээ нь тухайн орлогын 80 хувиас хэтрэхгүй байна
3	Алданги (ТЕХ 73)	Зохицуулалт байхгүй	Татварын хяналт шалгалтын томилолтыг олгосноос шийдвэр гарах хүртэл хугацаанд төлөөгүй татварт алданги тооцохгүй. Алдангийн нийт дүн нь хугацаандаа төлөөгүй татвар, эсхүл татварын албаны үндэслэлгүй илүү хураасан татварын үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.
4	Хууль даган мөрдөлтийн түвшин (ТЕХ 76)	Зохицуулалт байхгүй	Гааль, татварын алба хууль даган мөрдөлтийн түвшнийг дараах үндсэн шалгуур үзүүлэлтийн дагуу тогтооно: <ul style="list-style-type: none">• татвар төлөгчийн бүртгэл;• татварын тайлагнал;• татвар ногдуулалт, төлөлт;• татвар, гаалийн хууль тогтоомжийн зөрчил;• гаалийн бүрдүүлэлт.

Эдгээр хууль тогтоомжийн төсөл нь Улсын их хуралд өргөн баригдсан бөгөөд хараахан батлагдаагүй болно.

Та бүхэн татварын тогтолцоотой холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөх үйлчилгээ авахыг хүсвэл манай фирмийн утас, имэйл рүү холбоо бариарай.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
3-р хороо, Pearl tower А блок 902 тоот
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 8013-0414



Бэлтгэсэн хуульч

Б.Ариунзаяа (PhD)

Partner Lawyer

Email: ariunzaya@akp.mn

Tel: 77041414, 80270414

Read More on our website